

## **“GOLDEN MOUSE - DESIGN WEEK 2023” НААДМЫН УДИРДАМЖ**

### **Оюутан цагийн шилдэг бүтээл - Орчлонд танигдах Монгол брэнд**

“GOLDEN MOUSE - DESIGN WEEK 2023” наадам нь дизайны чиглэлээр сургалт явуулж буй сургуулиудын оюутан залуусын сэтгэлгээ, ур чадвар, уран бүтээлийн туршлагаа солилцох нэгдсэн талбарыг бий болгох, цаашлаад тэдний бүтээлийг олон нийтэд түгээх, дизайны чиглэлээр сургалт явуулж буй сургуулиудын сургалтын онцлогийг таниулах зорилгоор “Оюутан цагийн шилдэг бүтээл – Орчлонд танигдах Монгол брэнд” уриан дор “ИРЭЭДҮЙН НҮҮДЭЛ” сэдвийн хүрээнд 2023.05.01 - 2023.05.07 өдрүүдэд зохион байгуулагдах гэж байна.

### **ЗОРИЛГО**

Дизайны мэргэжлээр сурч буй оюутнуудын чөлөөт сэтгэлгээ, ур чадвар, уран бүтээл, сургалтын онцлогийг сурталчлах, бүтээлч хандлагыг дэмжих, дизайныг тодорхойлсон бодлого, концепцийг нийтэд таниулан түгээх зорилготой.

### **СЭДЭВ**

“ИРЭЭДҮЙН НҮҮДЭЛ” сэдвийн дор монгол агуулга, сэтгэлгээг тусгасан байна.

### **ҮЙЛ АЖИЛЛАГАА**

“GOLDEN MOUSE - DESIGN WEEK 2023” наадамд дараах үйл ажиллагаа явагдана. Үүнд:

- A. Оюутны бүтээлийн үзэсгэлэн, уралдаан. График дизайн, Анимаци, Энтертайнмент, Архитектур, Интерьер дизайн, Үйлдвэрлэлийн дизайн, Хувцасны дизайн, Хувцас үйлдвэрлэлийн загвар зохион бүтээлт, технологийн чиглэлээр сургалт явуулдаг их, дээд сургуулиудын оюутнуудын оролцсон бүтээлийн үзэсгэлэн, уралдаан 2023.05.05 - 2023.05.07 - ны өдрүүдэд зохион байгуулагдаж, шилдэг бүтээлийг номинаци тус бүрээр шалгаруулна.
- B. Дизайны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үзэсгэлэн: “GOLDEN MOUSE - DESIGN WEEK 2023” дизайны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үзэсгэлэн.
- C. “APPLY JOB” арга хэмжээ: “GOLDEN MOUSE - EXPO 2023” үзэсгэлэн дээр бизнесийн байгууллагуудын хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор “APPLY JOB” арга хэмжээ зохион байгуулагдаж, ажил олгогчдыг таниулах мөн тухайн байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэхэд нэн тэргүүнд тавигддаг ур чадваруудыг танилцуулах. (BOOTH)
- D. Бүтээгдэхүүн танилцуулга: “GOLDEN MOUSE - EXPO 2023” үзэсгэлэн дээр оюутанд зориулсан бүтээгдэхүүн танилцуулах. (BOOTH)
- E. Сурагчдын шилдэг бүтээлийн шалгаруулалт: “GOLDEN MOUSE - EXPO 2023” үзэсгэлэн дээр ЕБС – ийн сурагчдын бүтээлүүдээс шилдэг бүтээл шалгаруулна.

### **ХЭРХЭН ОРОЛЦОХ**

- Номинаци тус бүрд өөрсдийн сонирхол, хүсэл эрмэлзэл, авьяас, ур чадвараараа ганцаарчилсан төрлөөр болон баг бүрдүүлэн оролцоно.

- Дизайны мэргэжлийн чиглэлийг хамарсан бөгөөд дизайны шинэлэг үзэл санааг дэвшүүлсэн эсвэл бүтээгдэхүүнд хэрэгжүүлж болохуйц шийдэлтэй байна.
- 2022.06 сараас хойш хийгдсэн оюутны бүтээл байна.
- 2023.04.15 - 2023.04.25 - ны өдрүүдэд ШУТИС-ийн IV байр, ҮТС - ийн 217 тоот өрөөнд бүртгүүлнэ.
- 2023.04.21 - ны 15:00 цагаас ШУТИС - ийн IV байр, ҮТС - ийн 214 тоот ангид техникийн зөвлөгөөн болно.
- Оролцох сургуулийн бүртгэлийн хураамж болох 500,000 төгрөгийг 2023.04.20 - ний өдрөөс өмнө ШУТИС, ҮТС - ийн Голомт банкны 8115101742 тоот дансанд шилжүүлнэ. Оюутан хувиараа оролцвол 50,000 төгрөг төлнө.

### **ШАЛГАРУУЛАЛТАНД ОНЦЛОХ ЗҮЙЛС:**

- Бидний өдөр тутмын амьдралд шинээр гарч буй технологийн давуу талыг тусгасан эдлэхүүн, хувцас, орон зай болон мэдээллийн технологид тохирсон хэлбэрийг бий болгон зохиох, дадлага эзэмшсэн дизайнерын бүтээлч үйл ажиллагаа байна.
- Хүрээлэн буй орчны асуудалд дүн шинжилгээ хийхүйц үр дүнтэй, хэрэгцээтэй шийдэлд хүрч өөрчлөлт шинэчлэл хийх системтэй үйл ажиллагаа байна.
- Хэрэглэгчийн хэрэгцээ, гоо зүй, стандартын шаардлагыг хангасан эдлэхүүн, хувцас, интерьер болон график дизайн, визуал коммуникацийн шинэлэг шийдэлтэй бүтээл байна.

### **БҮТЭЭЛД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГУУД:**

- Уралдааны сэдвийн хүрээнд нийцсэн байх.
- Тухайн оролцогчийн өөрийн оюуны өмч байх. (Бусдын бүтээлийг ашигласан, хуулбарласан тохиолдолд уралдаанаас хасахыг анхаарна уу).
- Архи, тамхи, садар самуун сурталчилсан утга агуулгагүй байх.
- Хувь хүний нэр хүнд, хувийн нууцтай холбоотой хууль зөрчөөгүй байх.
- Самбарын ажлын хэмжээ нь А2 форматтай байх бөгөөд тоо хэмжээ хамаарахгүй.
- Видео файл нь mp4/h264/ форматаар 3 - 5 мин хугацаатай байна.

### **НОМИНАЦИУД:**

1. Визуал коммуникейшн дизайн (Visual communication design)
  - 1.1. Дүрийн шийдэл (Character design)
  - 1.2. Тоглоомын дизайн (Game design)
  - 1.3. Анимаци (Animation)
  - 1.4. Дижитал арт (Digital art)
  - 1.5. Брэнд дизайн (Display design, Brand design)

- 1.6. Гэрэл зураг (Advertising photography)
- 1.7. Постер дизайн (Poster design)
- 1.8. Номны дизайн (Comic design, Book and Magazine design )
- 1.9. Вэб хуудас болон утасны апп (UX/UI)
- 1.10. AR ба VR
2. Интерьер дизайн, архитектур (Interior design, Architecture)
  - 2.1. Интерьер дизайн (Interior design)
  - 2.2. Экстерьер дизайн (Exterior design)
  - 2.3. Архитектур (Architecture)
  - 2.4. Visualization of Interior & Exterior-CGI
3. Үйлдвэрлэлийн дизайн (Industrial design)
  - 3.1. Тоглоомын дизайн (Toy design)
  - 3.2. Сав баглаа боодлын дизайн (Packaging design)
  - 3.3. Бүтээгдэхүүний шинэ дизайн (New design of Product)
  - 3.4. Эдлэхүүний дизайн (Product design)
4. Хувцасны дизайн (Fashion design)
  - 4.1. Ирээдүйн үндэсний брэнд загвар
  - 4.2. Шилдэг цогц (ансамбль) загвар
  - 4.3. Уран сэтгэмжийн шилдэг загвар
  - 4.4. Материалын дизайны шинэлэг шийдэлтэй (sustainable) загвар
  - 4.5. Шилдэг зураг авалттай загвар
5. Ирээдүйн дизайнер (ЕБС - ийн сурагчид)
6. Оюутны эрдэм шинжилгээний хурал
7. Wascom таблет дээрх зургийн тэмцээн
8. “SKETCH” тэмцээн
9. Хакатон

**ХОЛБОО БАРИХ:**

Үйлдвэрлэлийн технологийн сургууль, ШУТИС, VIII хороо, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол улс.

Хариуцсан багш, холбогдох утас:

Зохион байгуулагч: Б. Мэндсайхан (99062211), О. Гантулга (99141728)

Визуал коммунікейшн дизайн: М. Номин (95661414)

Интерьер дизайн, архитектур: К. Жанбота (88007102)

Үйлдвэрлэлийн дизайн: Б. Мөнхзул (88006646) Хувцасны  
дизайн: П. Болормаа (88063225)

Имайл хаяг: [design@must.edu.mn](mailto:design@must.edu.mn)



**АЛТАН  
ХУЛГАНА"23**